



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/57

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


- 1.“Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” аяны хүрээнд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн суралцагчдын дунд “Шторк”-ийн уралдааныг зохион байгуулсугай.
- 2.Шторкийн уралдааны удирдамжийг 1 дүгээр, зарцуулагдах зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 3.Шторкийн уралдаанд зарцуулагдах 300,000 (гурван зуун мянга) төгрөгийг Хөтөлбөрт суурилсан арга хэмжээний зардлаас зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.
- 4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

2024 оны 04 -р сарын 24 ны өдрийн  
#157 дугаар захирамжийн 1-р хавсралт



**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЕБС-ИЙН СУРАЛЦАГЧДЫН ДУНД ЗОХИОН  
БАЙГУУЛАХ “ШТОРК”-ЫН УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

**ЗОРИЛГО:** Хүүхэд хамгааллын тогтолцоо, Хамтарсан багийн ажлыг эрчимжүүлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**ХАМРАХ ХҮРЭЭ:** VIII-XII ангийн суралцагчид.

**ХУГАЦАА:** 2024.04.22-29 хүртэл “**ШИВЭЭГОВЬ СУМЫН ХАМТАРСАН БАГ**” цахим хаягаар хүлээн авна.

**ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- Нэг баг 5 доошгүй гишүүнтэй байна.
- Бичлэг нь 5-8 минутанд багтсан байна.

**СЭДЭВ:**

- Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй.
- Мансууруулах бодис архи, тамхины хор нөлөө.
- Хүчирхийлэлгүй гэр бүл

**ШАГНАЛ:**


- ✓ 1-р байр Өргөмжлөл мөнгөн шагнал
- ✓ 2-р байр Өргөмжлөл мөнгөн шагнал
- ✓ 3-р байр Өргөмжлөл мөнгөн шагнал

**ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:**

**ШИВЭЭГОВЬ СУМЫН ХАМТАРСАН БАГ**

**Мэдээлэл авах утас: 94188828**

Сумын Засаг даргын  
2024 оны 04 -р сарын 24 -ны өдрийн  
...157... дугаар захирамжийн 2-р хавсралт



**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЕБС-ИЙН СУРАЛЦАГЧДЫН ДУНД ЗОХИОН  
БАЙГУУЛАХ “ШТОРК”-ЫН УРАЛДААНЫ ТӨСӨВ**

2024.4.24

№	Нэр	Тоо (ширхэг)	Ширхэгийн мөнгөн дүн	Нийт
<b>ЕБС-ийн 8-12 ангийн суралцагчид</b>				
1	I байр мөнгөн шагнал	1	120000	120.000
2	II байр мөнгөн шагнал	1	100.000	100.000
3	III байр мөнгөн шагнал	1	80.000	80.000
4	<b>НИЙТ ДҮН</b>			<b>300,000</b>